



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/102

Улаанбаатар хот

Байгууллагын стратеги төлөвлөгөө
боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн
батлах тухай

Монгол улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Дэд дарга

Гишүүд:

Хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн зохицуулалт, шалгалт тохируулгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмж, ложистикийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Эмийн чанар, аюулгүй байдлын тандалт судалгааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Шинэ эм, эмнэлзүйн судалгааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Чанарын хяналтын газрын ахлах, Эм, биобэлдмэлийн хяналтын улсын ахлах байцаагч

Эмийн бүртгэлийн зохицуулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

1422 010120

Эм үйлдвэрлэлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Эм шинжлэх лабораторийн чанарын ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Төлөвлөгөө, тайлан хариуцсан мэргэжилтэн

2.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын стратеги төлөвлөгөөг 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор боловсруулж, Даргын зөвлөлд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Д.Уранзаяа)-д даалгасугай.

3.Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, холбогдох мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг нийт газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

5.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан ЭЭХХЗГ-ын даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/20 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА